



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А1513

Есөнбулаг

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай" 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны "Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм батлах тухай" 211 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Индэрт багийн гэр хорооллын цахилгаан дамжуулах агаарын шугамын дэд станцыг өртгөтгөх ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Б.Бямбадорж	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн Ерөнхий архитектор)
Гишүүдэд:	М.Мандаххүү	(аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)
	Д.Отгонжаргал	(аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн эрчим хүчний хяналтын улсын байцаагч)
	Б.Лхагва-Очир	(Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн)
	П.Аззаяа	(Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахлах дэслэгч)
	Ж.Билэгсайхан	(Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн)
	Б.Бээжин	("Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ийн үйлдвэрлэл эрхэлсэн дэд захирал бөгөөд ерөнхий инженер)

2.

Р.Нямжаргал (Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын Захирагчийн ажлын албаны ахлах мэргэжилтэн)

Ц.Энхмэнд ("Хуруу цахир" ХХК-ийн захирал, гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга:Б.Цэрэндаваа (Газрын харилцаа, барилга, хот, байгуулалтын газрын барилга угсралт техник хяналт хариуцсан мэргэжилтэн)

2.Дэд станц өргөтгөх ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа ажил гүйцэтгэх гэрээ холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн дотор танилцуулахыг комисс (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

3.Холбогдох акт, баримт бичгийг үндэслэн орон нутгийн өмчид бүртгэхийг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг), барилга байгууламжийн урсгал зардлыг төсөвт тусгаж, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Есөнбулаг сумын Засаг дарга (А.Алтанхуяг)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ  Г.ЧИНБАТ

